



МОНГОЛ УЛСЫН
ХОНОГ ТУГМЫН ХЭВЛЭЛ
№ 07 дугаар сарын 22
№27 /696/

ЗВШААГ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

258

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

261

**Өмчлүүлэх газрын хэмжээ,
байршил, зориулалтыг тогтоох
тухай**

**Өмнөговь аймагт Бүсийн
оношилгоо, эмчилгээний төв
байгуулах тухай**



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|------|---|------------|------|
| 304. | Журамд нэмэлт оруулах тухай | Дугаар 122 | 1253 |
| 305. | Удирдах хороо байгуулах тухай | Дугаар 144 | 1254 |
| 306. | Ургамлын үр, үрслэг, суулгац, ургамал хамгааллын бодис, бордоог жинд нэг удаа нэвтрүүлэх хийшин боомтыг тогтоох тухай | Дугаар 146 | 1257 |
| 307. | Тэмдэглэлт өдрийн тухай | Дугаар 150 | 1258 |
| 308. | Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай | Дугаар 154 | 1258 |
| 309. | Өмнөговь аймагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах тухай | Дугаар 156 | 1261 |
| 310. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 157 | 1262 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 20 дугаар тогтоолоор баталсан "Хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 5.1-ийн "... алба/Хил хамгаалах байгууллагын шалган нэвтрүүлэх алба, ... гаалийн байгууллага/-ны" гэсний дараа "болон тагнуулын байгууллагын" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 5 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

Удирдах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2007 оны 186 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 5.1.3-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх шат дараалсан үйл явцыг удирдах чиг үүрэг бүхий Төрийн албаны шинэтгэлийг удирдах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Удирдах хорооны дүрмийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2011 оны 144 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙГ УДИРДАХ ХОРОО

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд

Орлогч дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

-Төрийн албаны зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр).

Гишүүд: -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;

-Төв аймгийн Засаг дарга;

-Үндэсний аудитын газрын дарга (зөвшилцсөнөөр);

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Ерөнхий сайдын, Засаг даргын хуульч, төлөөлөгч, Төрийн нарийн бичгийн дарга;



- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Авлигатай тэмцэх газрын дэд дарга (зөвшилцсөнөөр);
 - Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн (зөвшилцсөнөөр);
 - Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга;
 - Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга.
- Нарийн бичгийн дарга -Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)

Засгийн газрын 2011 оны 144 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙГ УДИРДАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн албаны шинэтгэлийг удирдах хороо (цаашид "Удирдах хороо" гэх) нь Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг хянах, үр дүнд нь үнэлгээ, дүгнэлт өгөх ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Удирдах хороо нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Удирдах хороо нь төрийн албаны шинэтгэлийн талаар мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж болно.

1.3. Удирдах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Удирдах хорооны хуралдаан байна. Удирдах хорооны гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

1.4. Удирдах хорооны хуралдаан асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолд Удирдах хорооны дарга, түүний эзгүйд Удирдах хорооны аль нэг орлогч дарга, хуралдааны тэмдэглэлд



Удирдах хорооны нарийн бичгийн дарга тус тус гарын үсэг зурна.

Хоёр. Удирдах хорооны чиг үүрэг

Удирдах хороо дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1. Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлгээ, дүгнэлт өгөх.

2.2. Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

2.3. Төрийн албаны хууль тогтоомжийг шинэчлэх, тэдгээрийн уялдаа холбоог хангах асуудлыг хариуцан зохион байгуулах.

2.4. Төрийн албаны шинэтгэлийг хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг уялдуулан зохицуулах, явц, үр дүнг хянаж, чиглэл өгөх.

2.5. Нутгийн удирдлагыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн шинэтгэлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах.

2.6. Төрийн албаны хүний нөөцийн болон цалин хөлсний нэгдсэн мэдээллийн сүлжээ бий болгох ажлыг уялдуулан зохион байгуулах.

2.7. Төрийн албаны шинэтгэлтэй холбоотой асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Бусад

3.1. Удирдах хорооны үйл ажиллагааны болон бусад шаардлагатай зардлыг Ерөнхий сайдын жил бүрийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

3.2. Удирдах хороо нь тогтоосон журмаар хийгэж тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 5 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар
хот**Ургамлын үр, үрслэг, суулгац, ургамал
хамгааллын бодис, бордоог жилд нэг удаа
нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай**

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.1.5, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Ургамлын үр, үрслэг, суулгац болон ургамал хамгааллын бодис, бордоог жилд нэг удаа 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд улсын хилээр нэвтрүүлж байх хилийн боомтыг дор дурдсанаар тогтоосугай:

1.1. Ургамлын үр, үрслэг, суулгац нэвтрүүлэх хилийн боомт:

- 1.1.1. Дорнод аймгийн Хавирга;
- 1.1.2. Завхан аймгийн Арцсуурь;
- 1.1.3. Говь-Алтай аймгийн Бургастай;
- 1.1.4. Хөвсгөл аймгийн Ханх.

1.2. Ургамал хамгааллын бодис, бордоо нэвтрүүлэх хилийн боомт:

- 1.2.1. Дорнод аймгийн Хавирга;
- 1.2.2. Ховд аймгийн Булган;
- 1.2.3. Баян-Өлгий аймгийн Цагааннуур;
- 1.2.4. Увс аймгийн Боршоо;
- 1.2.5. Завхан аймгийн Арцсуурь;
- 1.2.6. Говь-Алтай аймгийн Бургастай;
- 1.2.7. Хөвсгөл аймгийн Ханх.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүү нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД****Т.БАДАМЖУНАЙ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 5 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

Тэмдэглэлт өдрийн тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дэлхийн Улаан загалмайн өдөр-5 дугаар сарын 8-ны өдрийг Монгол Улсад "Хүмүүнлэгийн өдөр" болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-д "4.1.46. Хүмүүнлэгийн өдөр-жил бүрийн 5 дугаар сарын 8-ны өдөр" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн "2011 онд иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАТТУЛГА

2011 ОНД ИРГЭНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

| № | Аймаг, нийслэлийн нэр | Өмчлүүлэх газрын байршил | Иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ (га-гаар) | Өмчлүүлэх газрын зориулалт /га-гаар / | | | | Үүнээс | | |
|---|-----------------------------|--------------------------------|--|---|--|--|--|--------------------------|------------|---------------------------|
| | | | | Иргэнд үндэй өмчлүүлэх газрын нийт хэмжээ | Цаоо сээмшиж байгаа газрын нийт хэмжээ | Шинээр өмчлүүлэх газрын нийт хэмжээ | Улсын чанартай автомашын дагуу өмчлүүлэх газрын нийт хэмжээ | Аж ахуйн зориулалтаар | Үр тарианы | Төмс, хүнсний ноогооны |
| 1 | Архангай | Аймгийн болон сумын төвд | 291.07 | 290.97 | 134.03 | 144.05 | 12.89 | 0.1 | | 0.1 |
| 2 | Баян-Өлгий | Аймгийн болон сумын төвд | 368.70 | 344.70 | 222.6 | 122.1 | | 24 | 23 | 1 |
| 3 | Баянхонгор | Аймгийн болон сумын төвд | 104.90 | 89.90 | 49.86 | 39.12 | 0.9 | 15 | 15 | |
| 4 | Булган | Аймгийн болон сумын төвд | 583.56 | 551.42 | 294.21 | 241.48 | 15.73 | 32.14 | 32.14 | |
| 5 | Говь-Алтай | Аймгийн болон сумын төвд | 42.70 | 42.69 | 11.12 | 31.57 | | 0.01 | | 0.01 |
| 6 | Говьсүмбэр | Аймгийн болон сумын төвд | 100.25 | 100.25 | 16.25 | 61.6 | 22.4 | 0 | | |
| 7 | Дархан-Уул | Аймгийн болон сумын төвд | 945.27 | 398.67 | 293.84 | 27.68 | 77.15 | 546.6 | 529.6 | 17 |
| 8 | Дорноговь | Аймгийн болон сумын төвд | 99.28 | 99.26 | 13.4 | 85.86 | | 0 | | |

| | | | | | | | | | | | |
|-----------------|------------|--------------------------|----------|----------|---------|----------|--------|---------|--------|--------|-------|
| 9 | Дорнод | Аймгийн болон сумын төвд | 184.90 | 184.90 | 22.8 | 160.7 | 1.4 | 0 | | | |
| 10 | Дундговь | Аймгийн болон сумын төвд | 95.74 | 95.74 | 43.77 | 50.57 | 1.4 | 0 | | | |
| 11 | Завхан | Аймгийн болон сумын төвд | 162.95 | 160.90 | 66.44 | 77.46 | 17 | 2.05 | 2 | 0.05 | |
| 12 | Орхон | Аймгийн болон сумын төвд | 127.60 | 127.60 | 62.26 | 65.34 | | 0 | | | |
| 13 | Өвөрхангай | Аймгийн болон сумын төвд | 168.45 | 168.40 | 60.16 | 86.4 | 21.84 | 0.05 | | 0.05 | |
| 14 | Өмнөговь | Аймгийн болон сумын төвд | 324.58 | 119.87 | 9.06 | 107.31 | 3.5 | 204.71 | 184.71 | 20 | |
| 15 | Сүхбаатар | Аймгийн болон сумын төвд | 116.03 | 116.03 | 23.27 | 90.66 | 2.1 | 0 | | | |
| 16 | Сэлэнгэ | Аймгийн болон сумын төвд | 2851.65 | 1398.19 | 510.45 | 862.2 | 25.54 | 1433.46 | 1299 | 146 | |
| 17 | Төв | Аймгийн болон сумын төвд | 10134.58 | 10134.58 | 108.04 | 9401.1 | 625.44 | 0 | | | |
| 18 | Увс | Аймгийн болон сумын төвд | 174.48 | 168.45 | 132.64 | 34.83 | 0.98 | 6.03 | 6 | 0.03 | |
| 19 | Ховд | Аймгийн болон сумын төвд | 568.88 | 564.76 | 315.96 | 232.92 | 15.88 | 4.12 | 4 | 0.12 | |
| 20 | Хөвсгөл | Аймгийн болон сумын төвд | 487.08 | 260.03 | 178.2 | 79.23 | 2.6 | 227.05 | 1 | 181 | |
| 21 | Хэнтий | Аймгийн болон сумын төвд | 158.04 | 158.04 | 50.97 | 101.07 | | 0 | | | |
| 22 | Нийслэл | Нийслэлд | 104.73 | 104.73 | 104.73 | | | 0 | | | |
| Урсгал хэмжээнд | | | 18195.42 | 15680.10 | 2730.08 | 12103.27 | 846.75 | 2515.32 | 1833.6 | 606.85 | 74.87 |

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 156

Улаанбаатар
хот**Өмнөговь аймагт Бүсийн оношилгоо,
эмчилгээний төв байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.10 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн хүн амд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлгийн хүний нөөц, материаллаг баазад тулгуурлан байгуулсугай.

2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгыг засварлах, өргөтгөх, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах хөрөнгө болон эмч ажилчдын цалин, тусламж үйлчилгээний зардлын зөрүүг тооцож Монгол Улсын 2012 оны төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөвт тусган хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

3. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тооцон, эмч, сувилагч, мэргэжилтнээр хангах, тэдгээрийг давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Өмнөговь аймгийн Засаг дарга Б.Бадраа нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2001 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйлчлэх хүрээний аймаг, сум"-ын жагсаалтын 2 дахь заалтын "Дундговь, Өмнөговь" гэсэн хэсгийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД****С.ЛАМБАА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 157

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 1996 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Төрөөс баримтлах Соёлын бодлого"-ын 3.1 дэх заалт, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.6.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сонгодог урлаг-II" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тооцож, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад үе шаттайгаар жил бүр тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.
3. "Сонгодог урлаг-II" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2011 оны 157 дугаар
тогтоолын хавсралт

"СОНГОДОГ УРЛАГ-II" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл

Соёлын тухай хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичигт сонгодог урлагийг төрийн ивээлд байлган судлан сурталчлах, хөгжүүлэх талаар заасан. Энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2001 оны 266 дугаар тогтоолоор "Сонгодог урлаг" хөтөлбөр (2001-2008)-ийг үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой хослуулан хөгжүүлэх нөхцөл бололцоог



хангах, хүн амын гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, шинэ уран бүтээл туурвиж урын сангаа баяжуулан дэлхийн болон өрнө, дорнын сонгодог урлагийн хөгжлийн түвшинд хүргэх зорилго, зорилтын хүрээнд батлан хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд дуурь, балет, симфони зэрэг уран бүтээлийг шинээр болон сэргээн тавьсны үр дүнд сонгодог урлагийн урын сан баяжиж, уралдаан наадмууд тогтмолжиж, уран бүтээлчдийн ур чадвар өсөж, сонгодог урлагийн үзэгчдийн тоо нэмэгдсэн байна.

Дуурь бүжгийн эрдмийн театр, Улсын драмын эрдмийн театр, Улсын хүүхэддэйн театр, Улсын филармони болон Улсын цирк, Хөгжим бүжгийн коллеж зэрэг байгууллагуудад хөгжмийн зэмсэг, гэрэл дууны тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээ хийгдэж, манай улсын соёл, урлагийн салбарын хөгжилд тодорхой үр дүн гарсан байна.

Ийнхүү "Сонгодог урлаг" хөтөлбөр хэрэгжсэнээр зарим ахиц дэвшил гарсан хэдий ч цаашид сонгодог урлагийн урын санг улам бүр баяжуулж, хүртээмжийг тогтворжуулахын тулд уран бүтээлчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэжлийн урлагийн байгууллагуудын тогтвортой ажиллагааг баталгаажуулах эдийн засаг, санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх, сонгодог урлагийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлж, хүүхэд залуучууд, иргэдийн урлагийн боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага их байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Сонгодог урлагаар дамжуулан хүн амд гоо зүйн мэдлэг боловсрол олгох, олон нийтийн оролцоо, нийгмийн түншлэлд тулгуурлан сонгодог урлагийг сурталчлах үйл ажиллагааны хүртээмж, чанар, үр ашгийг өргөжүүлэх замаар:

2.1.1. сонгодог урлагийг хөгжүүлэх, сурталчлахад чиглэсэн эрх зүй, менежмент, санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэх;

2.1.2. сонгодог урлагийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих;

2.1.3. хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, уран бүтээлчдийн тасралтгүй сурах, хөгжих, ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг соёлын салбарын хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомж, бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулах.

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, сонирхогч



талын эрэлт хэрэгцээ, оролцоог хангасан байх.

3.3. Сонгодог урлагийн үр өгөөжийг иргэн бүр хүртэх боломжийг бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлж, дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1. Сонгодог урлагийг хөгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоо, эрх зүй, санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэх:

4.1.1. мэргэжлийн урлагийн байгууллагын удирдлагын тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх;

4.1.2. мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагаа, орчин нөхцөлд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар төрийн өмчийн театр, чуулгуудын материаллаг баазыг бэхжүүлэх;

4.1.3. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг сонгон шалгаруулалтаар явуулж, чиглэл болон болзол, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

4.1.4. төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан сонгодог урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, санхүүгийн дэмжлэгийн үр ашигтай хэлбэрүүдийг нэвтрүүлэх;

4.1.5. сонгодог урлаг хөтөлбөрийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, улсын болон орон нутгийн төсөвт жил бүр хөрөнгө тусган санхүүжүүлэх;

4.1.6. мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос сонгодог урлагийг сурталчлах, шинэ уран бүтээл туурвих, хүний нөөц бүрдүүлэхэд зориулан зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх.

4.2. Сонгодог урлагийн урын санг баяжуулах, уралдаан, наадам, арга хэмжээ зохион байгуулах, сурталчлахад чиглэгдсэн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх:

4.2.1. дуурь, балет, хөгжим, драмын жүжгийн бүтээлийг шинээр болон сэргээн тавих;

4.2.2. аймаг, нийслэлээс алслагдсан дүүрэг, сумдын иргэдэд сонгодог урлагийн шилдэг уран бүтээлийн тоглолтыг хүргэж, соёлын үйлчилгээг өргөжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулах;



4.2.3. сонгодог бүтээлийн тайз, хувцас, бичлэг, дарамж (клавир), удирдбар (партитура)-ыг хадгалж хамгаалан, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

4.2.4. уран бүтээлчдийг олон улсын хэмжээний уралдаан, наадамд оролцуулах;

4.2.5. сонгодог урлагийн уралдаан, наадмыг орон нутаг, улс, олон улсын хэмжээнд өргөжүүлэн зохион байгуулах;

4.2.6. хүүхдэд урлагийн боловсрол олгоход чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

4.2.7. дэлхийн болон үндэсний дүрслэх урлагийн сонгодог бүтээлийг дэлгэн үзүүлэх, энэ чиглэлээр судалгаа, сурталчилгааны үйл ажиллагааг эрхлэх урлагийн галерей байгуулах асуудлыг судалж төсөл боловсруулах;

4.2.8. уран бүтээлчдийг алдаршуулах, тэдний уран бүтээлийг сурталчлах ажлыг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах;

4.2.9. сонгодог урлагийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн санал, санаачилгыг дэмжих.

4.3. Сонгодог урлагийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, тэднийг тасралтгүй хөгжих нөхцөл, боломжоор хангахад дэмжлэг үзүүлэх:

4.3.1. ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн хичээлийн стандарт, сургалтын агуулга, хөтөлбөрт сонгодог урлагийн талаар зохих мэдлэгтэй болгоход чиглэгдсэн сэдвийг тусгаж, сурагчдын сонгон суралцах боломжийг нэмэгдүүлэх;

4.3.2. дотоод, гадаадын мэргэжлийн урлагийн сургуульд элсэгчдийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх замаар сонгодог урлагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тэдэнд зориулсан ажлын байрыг бий болгох, захиалгаар сургах, энэ чиглэлээр суралцагчдад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах;

4.3.3. урлагийн байгууллагад мэргэжлээрээ үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг давтан сургах, дадлагажуулах талаар ажил олгогчоос гаргаж буй санаачилгыг дэмжих;

4.3.4. мэргэжлийн урлагийн сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор тэднийг төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжлийн багш нарыг гадаадаас урьж ажиллуулах;

4.3.5. төвийн болон орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагын удирдлага, уран бүтээлч, ажилтны мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

4.3.6. мэргэжлийн урлагийн байгууллагын ажлын байрны судалгаа, хэрэгцээ шаардлага дээр үндэслэн нэн шаардлагатай мэргэжлээр суралцагч элсүүлэх, тэдний суралцах идэвх, сонирхлыг хөхиүлэн дэмжих



зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын нэрэмжит тэтгэлэг бий болгон, түүнийг олгох журам боловсруулан батлах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1. "Сонгодог урлаг-II" үндэсний хөтөлбөрийг 2011-2016 онуудад хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- улсын болон орон нутгийн төсөв;
- соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгө;
- гадаад орон, олон улсын байгууллагын хандивын хөрөнгө;
- аж ахуйн нэгжийн хандивын хөрөнгө;
- бусад эх үүсвэр.

| Хэрэгжүүлэх хугацаа /онoor/ | Улсын төсвөөс /сая.төг/ |
|-----------------------------|-------------------------|
| 2011 | 1.495.0 |
| 2012 | 2.215.0 |
| 2013 | 2.138.0 |
| 2014 | 2.303.0 |
| 2015 | 2.211.0 |
| 2016 | 1.478.0 |
| Нийт | 11.840.0 |

Зургаа. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дараахь үүрэг хүлээнэ:

6.1. Засгийн газар:

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нягт уялдуулах;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хамтран ажиллах;
- хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжих.

6.2. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:



-хүн төрөлхтөний соёлын үнэт өв сонгодог урлагийн түүх, уламжлал, урлагийн бүтээлийг туурвиж иргэдэд хүргэх зорилгоор тэдгээрийг судлан сурталчлах, өвлөн уламжлуулах, бүтээн туурвих, хамгаалах ажлыг зохион байгуулах;

-сонгодог урлагийг хөгжүүлэх стратегийг тодорхойлж, түүнийг үе шаттай хэрэгжүүлэх, сонгодог урлагийг хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх;

-төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, сонгодог урлагийг дэмжих сонирхогчдын нэгдэл, холбоо, авъяастнуудтай хамтран ажиллах;

-сонгодог урлагийг дэмжих чиглэлээр тодорхой үр дүнтэй ажилласан хамтлаг, нэгдэл, холбоо, авъяастнуудыг урамшуулан дэмжих;

-хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бусад байгууллагуудаас зохиож байгаа ажилд идэвхтэй оролцох, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

6.3. Нутгийн захиргааны байгууллага:

-хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

-хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллага (орон нутгийн хэвлэл мэдээлэл, соёл, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж), иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж удирдлагаар хангаж ажиллах.

6.4. Хэвлэл, мэдээллийн байгууллага:

-сонгодог урлагтай холбогдох сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлэх, тэдгээрийн чанарыг дээшлүүлж, арга хэлбэрийг боловсронгуй болгох;

-сонгодог урлагийн уран бүтээлч, авъяастныг дэмжин, тэдний бүтээл, авъяас чадварыг нийтэд сурталчлах.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, төлөвлөлтөөр ханган зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

7.2. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохион байгуулах ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Соёл, урлагийн хороо хариуцна.

7.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн



түвшинд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулах үүргийг аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газар, сонгодог урлагийн талаар сургалт, сурталчилгаа явуулах үүргийг мэргэжлийн соёл, урлагийн байгууллага хариуцна.

7.4. Соёл, урлагийн хороо нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан ажлаа жил жилээр төлөвлөн хэрэгжүүлж соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

7.5. Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн үйл ажиллагааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хөтөлбөрийн явц, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулна.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

8.1. Хөтөлбөрт тусгагдсан эрх зүйн орчин болон үйл ажиллагаа, стандартын байдалд хөндлөнгийн шинжээчийн хийсэн үнэлгээ, дүгнэлт.

8.2. Сонгодог урлагийн уралдаан, наадам, сургалт, зөвлөлгөө, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, түүний үр нөлөө, тэдгээрийн үр дүн, төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны өсөлт.

8.3. Соёлын байгууллагын хүний нөөцийн чадавхи сайжирсан байдал, шинээр болон сэргээн туурвисан уран бүтээлийн тоо, чанарын өсөлт.

8.4. Сонгодог урлагаар үйлчилдэг мэргэжлийн урлагийн байгууллагын техник, тоног төхөөрөмж нь технологийн шинэчлэл хийгдэж олон улсын стандартын түвшинд нийцсэн байдал.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакция,


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487